



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 442

Улаанбаатар хот

Г Тарифт өөрчлөлт оруулах тухай Г

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2, 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-тай байгуулсан 02/2021 тоот гэрээ, урамшуулалт зохицуулалтын гэрээ дүгнэсэн акт, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-иас ирүүлсэн саналыг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Тариф батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд “4,459,071.7” гэснийг “4,597,171.7” болгож өөрчилсүгэй.

2. Энэхүү өөрчлөгдсөн диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллахыг “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК (Г.Балжинням), “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (Р.Дагдан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Эрхэмбаяр)-нд даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ



• 220010928